



ХЭНТИЙ АЙМГИЙН
БАТНОРОВ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2025 оны 08 сарын 18 өдөр

Дугаар А/133

Батноров сум

Газар эзэмшүүлэх эрхийн
дуудлага худалдаа явуулах тухай


Монгол улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Газрын тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.1.2 дахь заалт, Сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2024 оны "Сумын 2025 оны Газар зохион байгуулалтын төлөвлөгөө батлах тухай" 15 дугаар тогтоолын 5 дугаар хавсралт, Газар зохион байгуулалт, геодези зураг зүйн ерөнхий газрыг даргын 2025 оны "Аргачлал шинэчлэн батлах тухай" А/188 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Батноров сумын Бэрх 7 дугаар багийн Төмөртэй өндөрт байршилтай 55000 квадрат метр уул уурхайн үйлдвэрлэлийн барилга, байгууламж зориулалттай газрын дуудлага худалдааг 2025 оны 09 дугаар сарын 03-ны өдөр цахим хэлбэрээр зохион байгуулсугай.

2. Батноров сумын Бэрх багийн Төмөртэй өндөрт байршилтай 55000 квадрат метр уул уурхайн үйлдвэрлэлийн барилга, байгууламж зориулалттай газрын худалдааны анхны үнийг 35,196,800 (гучин таван сая нэг зуун ерэн зургаан мянга найман зуу) төгрөгөөр тогтоосугай.

3. Дуудлага худалдааг холбогдох хууль, тогтоомжийн дагуу зохион байгуулах бэлтгэл ажил хангахыг Бэрх хотын газрын даамал (Т.Очирбат)-д үүрэг болгосугай.

ДАРГА



Г.ОТГОНБАЯР

230531052